

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 2023 оны 11 дүгээр сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

Арга хэмжээ: Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр 2022 онд төлөвлөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр гүйцэтгэгч байгууллагатай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “нууц” гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг үндэслэн ажлын даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар 2022 онд санхүүжилт болох 470.0 сая төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 100 хувь гүйцэтгэгчид олгосон.

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем” (ISM) (одоо ашиглаж байгаа хуучин систем) дэх визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний бүртгэл хэсгийн үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд 10 дугаар сарын 30-ны өдрөөс бүрэн нэвтрүүлж, хүсэлтийг хүлээн авч байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 11 дүгээр сарын 02-ны өдрөөс танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системтэй холболоо. Энэ онд хөгжүүлэлтэд төсөв зарцуулаагүй.

Энэхүү арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлж байгаа тул 11 дүгээр сард хэрэгжилт 90 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг бууруулахгүйгээр бүрэн хангаж, жилийн эцэст хэвийн явагддаг болсон байхад анхаарч сайжруулах шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР